

БАТЛАВ:
“БАЯНХОНГОР-ЭРЧИМ ХҮЧ” ЦТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.УЛАМБАЯР

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2023 оны 10 дугаар сарын 09

№2023/074

Баянхонгор

1. *Хэрэглэгчийн нэр хаяг.* ДУУРСАХ БАГТ БАРИГДАХ 280 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ
2. *Хэрэглэгчийн байршил.* БАЯНХОНГОР СУМ ДУУРСАХ БАГИЙН ЗҮҮН ХОЙНО
3. *Ажил үйлчилгээний зориулалт:* ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТТАЙ
4. *Техникийн нөхцөл олгох үндэслэл:*

АИХТөлөөлөгчийн ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн

5. *Суурилагдсан чадал:* **Оролт1-126.4кВт оролт2-124.4кВт**

6. *Тоолуур:*

Барилгын ерөнхий щит тус бүр дээр 3 фазын тоолуурыг 5А бүрэн электрон ухаалаг тоолуур гүйдлийн трансформаторыг ачаалалд тохируулж суурилуулж өгнө. /Тоолуурын мэдээллийг ашиглагч байгууллагаас авах /

7. *Холбогдох цэг:*

6-р багт шинээр баригдаж буй АТП дэд станцын 0.4кВ-ын гаргалгаанаас барилгын щит тус бүрт хүртэл 3*150+1*120 хос кабель татна.

8. *Тусгай заалтууд:*

- *Барилгын гадна цахилгааныг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн компаниар хийлгэж ил далд акт гаргуулж хүлээн авна.*
- *Барилгын газардуулгыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж актаар баталгаажуулах.*
- *Барилгын гадна цахилгаан хангамжийг Баянхонгор аймгийн ГХБХБГазартай хамтран гаргасан трассын дагуу стандартын дагуу хийж гүйцэтгэх.*
- *Кабель шугам болон дэд станцын хамгаалалтын зурвасыг ГХБХБГ-т албан хүсэлт өгч мэдээллийн санд оруулах.*
- *Гадна цахилгаан хангамжийн трассын зургийг газрын албатай зөвшилцөнө.*
- *Дэд станцын гадна талд хайс хамгаалалт хийнэ. Мөн гадна цахилгаан хангамжийг улсын комиссоор барилга байгууламж хүлээн авсан үед хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.*

9. *Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх*

9.1. Дэд өртөөний болон кабель шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, хот байгуулалт стратеги бодлого төлөвлөлтийн хэлтсээр батлуулж, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах

9.2. Кабель шугамын трасс, хамгаалалтын зурваст барилга барих, зам талбай засахыг хориглоно. Шаардлагатай тохиолдолд кабелийг таг бүхий тусгай сувагт байрлуулах

9.3. Дэд өртөөний болон шитний газардуулгыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж, протокол авсан байх

9.4. Цахилгаан угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм болон Техник ашиглалтын дүрэм дагуу гүйцэтгүүлэх
“ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭХ” дүрмийн “дөрөв”-ийн 22.23-р замалтын дагуу “Баянхонгор эрчим хүч” ЦТ ХХК-аар хянуулж, шугам сүлжээнд холбох хүчдлийн түвшингийн ±10-ийн хэлбэлзлэлд зохицсон тоноглол суурилуулах

9.5. Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн заалтыг мөрдлөг болгох

9.6. “ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ”-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийлгэх

9.7. Хэрэглэгч нь “ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ” –ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.

9.8. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

9.9. “МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ”-ийн болон “ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ”-ийн заалтуудыг дагаж мөрдөх






9.11. Цахилгаан эрчим хүчний тооцоог “Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК-ийн санхүүтэй хийх

9.10. Бусад: Трансформатор бүрэн ачаалагдаагүй тохиолдолд хоосон явалтын болон шугамын алдагдлыг тус компанитай гэрээ хийн төлөх

9.11. Хэрэглэгч нь “ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ” –ийн 30.1.13 заалтын дагуу тус объектыг улсын комисс хүлээн авснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагад шилжүүлэн өгнө.

9.12. Энэхүү техникийн нөхцлийн дагуу холболтыг 3 жилийн хугацаанд хийж, гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

9.13. Тухайн объектын ерөнхий гүйцэтгэгч компани техникийн нөхцөлийн үнийг бүрэн хариуцан төлнө.

КОМИССЫН ДАРГА  Б.БАДАМЦЭЦЭГ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Д.БАТХҮЛЭГ
ГИШҮҮД  А.ЛХАГВАДОРЖ
 Ч.ГЭРЭЛТУЯА
 М.ДАВААДАЛАЙ

ХУРААМЖ-Барилгын зураг төсөл хийгдэж байгаа барилга баригдах үед дахин техникийн нөхцөл авна.

Утас: 88885069